



**ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМ**

**“АЛСЫН ХАРАА 2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН
ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМНЫ 2025 ОНЫ
ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

**УЛААНБААТАР
2025 ОН**

**“АЛСЫН ХАРАА 2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН
БОДЛОГЫН 2025 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2025 оны 10 дугаар сарын 06-ны өдөр

Улаанбаатар хот

**Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго,
үндэслэл, арга зүй**

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь “Алсын хараа – 2050” хөтөлбөрт туссан арга хэмжээний 2025 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үйл ажиллагааны гүйцэтгэлийг тавьсан зорилт, хүрэх түвшинтэй нь харьцуулан үр дүнг үнэлэх, дүгнэх, зөвлөмж гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Төлөвлөсөн арга хэмжээнүүдийн 2024 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээг хийхдээ Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан “Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг удирдлага болгов.

Арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн түвшинг үнэлэн тогтоохдоо дээрх журмын “Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй” болон үр дүн, нотлох баримтад тулгуурлах зарчмыг баримталлаа.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

“Алсын хараа – 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт туссан 15 зорилтын 74 арга хэмжээний 2025 оны 10 дугаар сарын байдлаар хэрэгжилтийг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны газар, хэлтэс, харьяа, салбар тус бүр хариуцсан ажил үүрэг, чиглэлийн дагуу тайлагнасан байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дараах үр дүнгүүд гарлаа.

1. 30 хувийн хэрэгжилттэй -8 арга хэмжээ
2. 40 хувийн хэрэгжилттэй -2 арга хэмжээ
3. 50 хувийн хэрэгжилттэй -6 арга хэмжээ
4. 60 хувийн хэрэгжилттэй -2 арга хэмжээ
5. 70 хувийн хэрэгжилттэй -6 арга хэмжээ
6. 80 хувийн хэрэгжилттэй -1 арга хэмжээ
7. 85 хувийн хэрэгжилттэй -1 арга хэмжээ
8. 90 хувийн хэрэгжилттэй – 26 арга хэмжээ
9. 100 хувийн хэрэгжилттэй -17 арга хэмжээ
10. Үнэлэх боломжгүй -5 арга хэмжээ тус тус байна.

Үнэлэх боломжгүй 5 арга хэмжээний хувьд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам үндсэн хариуцагчаар биш байх тул хэрэгжилтийн биелэлт гарах боломжгүй байсан тул үнэлэх боломжгүй гэж үзэв. Иймээс 69 арга хэмжээний дунджаар үнэлгээ хийхэд 77.7 хувьтай буюу бодлогын баримт бичгийн үр дүн хүлээгдэж байгаа түвшинд хэрэгжиж байна гэж үзлээ.

Гэвч уг бодлогын баримт бичигт туссан үйл ажиллагааны чиглэл тус бүрээр үнэлгээ хийвэл Хүний хөгжил хэсэгт туссан 3 арга хэмжээний дундаж 86.6, Засаглал хэсэгт туссан 23 арга хэмжээний дундаж 88.7 хувьтай буюу үр дүнтэй хэрэгжиж байна гэж үзлээ. Тодруулбал Цахим засаглалыг хөгжүүлэхэд шаардлагатай мэдээллийн технологийн салбарын стандарт, тушаал шийдвэр, дүрэм, журмыг боловсруулж батлах ажил амжилттай хэрэгжсэн байгааг дурдах нь зүйтэй байна. Тухайлбал Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Цахим гарын үсгийн тухай, Хүний хувийн

мэдээлэл хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулга болон Кибер аюулгүй байдлын тухай хуулийг Улсын Их Хурлын 2021 онд батлуулж, 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн.

Үүнтэй холбоотойгоор цахим хөгжлийн багц хуулийг даган батлуулах захиргааны хэм хэмжээний 43 актын хувьд Засгийн газраар батлуулах 23 актаас 19 акт, цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлах 18 актаас 12 актыг тус тус батлуулсан байна.

Мөн тус яамнаас төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор боловсруулсан 120 хуулийн төслийг Монгол Улсын Их Хуралд 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдөр өргөн мэдүүлсэн ба зарим хуульд тухайн төрлийн харилцааг мэдээллийн системийг ашиглан цахим хэлбэрээр зохицуулах боломжгүй зэрэг шалтгаанаар 11 хуулийн төслийг буцаан татаж, нэр бүхий 109 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулан батлуулсан байна.

Уг томоохон арга хэмжээг авч хэрэгжүүлснээр Алсын хараа 2050 урт хугацааны бодлогын Засаглал хэсэгт туссан тус яаманд хамаарах зорилтуудын биелэлт зэрэг үр дүнд хүрсэн амжилттай байгааг цохов.

Хүснэгт 1: “Алсын хараа – 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийг үйл ажиллагааны чиглэлээр харуулсан байдал.

№	Үйл ажиллагааны чиглэл	Зорилт	Арга хэмжээ	Арга хэмжээний дундаж хувь
1	Хүний хөгжил	1	3	86,6
2	Эдийн Засаг	4	15	66,9
3	Засаглал	3	23	88,7
4	Амар тайван аюулгүй нийгэм	3	27	72,7
5	Улаанбаатар ба дагуул хот	4	6	60
	Нийт	15	74	77,7

Нийт 69 арга хэмжээний хангалтгүй хэрэгжсэн хэд хэдэн арга хэмжээг дор дурдав. Үүнд:

Арга хэмжээ 4.2.29. “Мэдээллийн технологийн салбарыг экспортод чиглүүлэн хөгжүүлэх институцийн тогтолцоог бүрдүүлэх” төлөвлөлтийн биелэлтийг Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 04 дүгээр албан даалгаврын хүрээнд “Дэвшилтэт технологид суурилсан инновац, гарааны бизнесийг хөгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж болон гарааны компаниудыг хөгжүүлэх арга хэмжээний” төсөл боловсруулан Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар ажиллаж байна. Тус арга хэмжээний төсөлд Олон улсын хамтын ажиллагаа, сүлжээг өргөжүүлэх замаар экспортыг дэмжих арга хэмжээнүүдийг тусгасан гэж тайлагнасан буюу төлөвлөгөөг хэрэгжүүлэх шатанд ажиллаж байх тул 30 хувиар үнэлгээ хийв.

Арга хэмжээ 4.2.31. “Мэдээллийн технологийн кластерыг хөгжүүлж, гадаад зах зээлд гарахад дэмжлэг үзүүлэх” төлөвлөлтийн хувьд Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд “Мэдээллийн технологийн төрөлжсөн хаб/хамтын оффис байгуулах ТЭЗҮ, зураг төслийн ажил хийж гүйцэтгэх” зөвлөх үйлчилгээний ажил хийгдэж байгаа бөгөөд гүйцэтгэгч компанийн үнэлгээний аргачлалын дагуу 6 бүсийн Хэнтий, Орхон, Архангай, Дархан-Уул, Өмнөговь, Ховд аймгуудад тус хабыг байгуулахаар шийдвэрлэсэн. Уг шийдвэрийн дагуу сонгогдсон аймгуудын Засаг даргын тамгын газартай холбогдон байршлуудыг баталгаажуулан ажиллаж байна гэж тайлагнасан байх тул 30 хувиар үнэлгээ хийлээ.

Мөн арга хэмжээ 4.3.23. "Хиймэл оюун ухаанд суурилсан хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээг нэвтрүүлэх" төлөвлөлтийн хувьд "Их өгөгдөл, хиймэл оюуны үндэсний стратеги"-ийн төслийг боловсруулан Засгийн газрын 2025 оны 9 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдаанд танилцуулсан. Стратегийн хүрээнд нийгэм, эдийн засгийн тэргүүлэх салбарын тулгамдаж буй асуудлыг хиймэл оюун ашиглан шийдвэрлэх арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан гэж тайлагнасан байх тул дээрх төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажиллагаа бэлтгэл ажлын хүрээнд явагдаж байна гэж үзэж 30 хувиар үнэлгээг хийлээ.

Түүнчлэн арга хэмжээ 7.5.13 "Сансрын холбооны үндэсний хиймэл дагуулын сүлжээ ашиглан үндэсний харилцаа холбооны сүлжээний ашиглалт, хяналтын менежментийг бүрдүүлэх, уялдуулах сайжруулах сүлжээг өргөтгөн байгуулж ашиглалтын хэвийн нөхцөлийг хангаж ажиллах, төрийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах цогц үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх" төлөвлөгөөний биелэлтийг Сансрын холбооны үндэсний хиймэл дагуулын сүлжээ бий болгоход шаардлагатай дараах ажлуудыг гүйцэтгэсэн. Үүнд:

Харилцаа холбооны Үндэсний хиймэл дагуул төсөлд БНФУ-ын Талес Алениа Спейс компанитай Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам хамтран ажиллах талаар харилцан ойлголцлын санамж бичгийг 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдөр байгуулсан. Хоёр тал хамтран харилцаа холбооны үндэсний хиймэл дагуулын техникийн нөхцөлийг тодорхойлох, гэрээний төсөл боловсруулахаар хамтран ажиллаж байна.

Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газраас Монгол Улс үндэсний, бие даасан хиймэл дагуултай болох төслийг санхүүжүүлэх шийдвэр гаргасныг мэдэгдэн Франц Улсын Төрийн сангийн Ерөнхий газраас санхүүжилтийн саналыг тусгасан албан захидлыг 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдөр Монгол Улсад суугаа элчин сайдаараа дамжуулан Монгол Улсын Сангийн яаманд ирүүлсэн.

Сангийн сайдын 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 93 дугаар тушаалаар "Монгол Улсын харилцаа холбооны үндэсний хиймэл дагуулын төсөл"-ийн саналыг Бүгд Найрамдах Франц Улсын талтай хэлэлцэх, Зээлийн хэлэлцээ хийх Сангийн яам, Гадаад харилцааны яам, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Эдийн засаг, хөгжлийн яамны албаны төлөөллүүд оролцсон хамтарсан ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байгаа болно гэж тайлагнасан байх тул Хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан, техникийн нөхцөл, гэрээний төсөл боловсруулах ажлууд хийгдэж байгаа, санхүүжилтийн санал ирсэн, холбогдох ажлын хэсэг ажиллаж байгаа хэдий ч хиймэл дагуулыг бүрэн байршуулж ашиглалтад оруулаагүй байх тул төсөл бүрэн хэрэгжээгүй гэж үзэж 40 хувиар үнэлгээг хийв.

Арга хэмжээ 7.5.27. "Сансрын холбооны үндэсний хиймэл дагуулын сүлжээ ашиглан үндэсний харилцаа холбооны сүлжээний ашиглалт, хяналтын менежментийг бүрдүүлэх, уялдуулах сайжруулах сүлжээг өргөтгөн байгуулж ашиглалтын хэвийн нөхцөлийг хангаж ажиллах, төрийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах цогц үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх" төлөвлөлтийн хувьд мөн адил биелэлтийг оруулсан байсан ба Харилцаа холбооны Үндэсний хиймэл дагуул төслийн харилцан ойлголцлын санамж бичиг байгуулагдсан, техникийн нөхцөлийг тодорхойлох, гэрээний төслийг боловсруулахаар ажиллаж байгаа бөгөөд Франц Улсаас санхүүжилтийн санал ирсэн, Монгол Улсын холбогдох байгууллагууд хамтарсан ажлын хэсэг байгуулсан боловч хиймэл дагуулын угсралт, туршилт, ашиглалтад оруулалт, сүлжээний бүрэн ажиллагаа одоогоор хийгдээгүй тул зорилтын хэрэгжилт бүрэн бус гэж үзэж 40 хувиар үнэлгээ хийв.

Энэ мэтчилэн 10 арга хэмжээний хувьд үйл ажиллагааг эхлүүлэх шатанд ажиллаж байсан тул үнэлгээг 30-40 хувиар хийлээ.

Мөн биелэлтийн явц ахицтай байгаа хэд хэдэн зорилт арга хэмжээний талаар дурдвал:

Арга хэмжээ 5.3.16. "Төрийн байгууллагын албан хэрэг хөтлөлт, албан бичиг солилцооны үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлж, сүлжээг бий болгох" ажлын биелэлт хангалттай буюу үр дүнгээ өгсөн ба цаашид өсөлттэй тайлан мэдээ гарах боломжтой байгааг харгалзан үзэж 100 хувиар үнэлгээг хийсэн болно.

Тодруулбал Төрийн захиргааны төв болон Зэвсэгт хүчний жанжин штаб, Оюуны өмчийн газар, Соёл, урлагийн газар, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар, Шүүх шинжилгээний ерөнхий газраас бусад Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлагууд, 20 аймгийн Засаг даргын Тамгын газар (Увс аймгийн ЗДТГ холбогдоогүй) зэрэг нийт 1887 байгууллага албан бичиг солилцооны дундын системд холбогдож, 2024 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар 89,465 албан бичгийг илгээж, 108,149 албан бичиг хүлээн авсан тоон үзүүлэлт бүртгэгдээд байна. Албан бичиг солилцооны дундын системд холбогдсон байгууллагуудын 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн байдлаарх үзүүлэлтийг дурдвал 2906 байгууллагын 276,246 албан бичгийг илгээж, 318,872 албан бичиг хүлээн авсан тоон үзүүлэлт бүртгэгдсэн байна.

Мөн арга хэмжээ 5.6.8. "Төрийн байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж авлига үүсэх эрсдэлийг бууруулах" төлөвлөгөөний хэрэгжилт ахицтай буюу иргэдэд төрийн байгууллагаас олгодог баримт бичиг, гэрчилгээ, зөвшөөрөлтэй холбоотой төрөл бүрийн мэдээлэл, мэдэгдлийг Мэдэгдэл хүргэх систем (www.E-Mongolia.mn)-ээр дамжуулан авах боломжийг бүрдүүлж, иргэдэд 2025 оны эхний хагас жилийн байдлаар нийт 35,668,892 мэдэгдлийг хүргэсэн. Үүнээс үндэсний цахим шуудан (73.7% буюу 26,318,442), хувийн цахим шуудангийн хаяг (1.4% буюу 442,286), Push Notification (24.9% буюу 8,908,164)-ээр дамжуулан хүргэсэн. Төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгож, нээлттэй, ил тод, шуурхай байлгах зорилгоор төр, иргэнийг холбосон мэдээлэл дамжуулах цахим суваг болох Үндэсний цахим шуудангийн систем (www.mail.e-mongolia.mn)-ийг нэвтрүүлж, 2 сая хэрэглэгчид мэдэгдэл хүргэх боломжийг бүрдүүлсэн.

Мөн Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор батлагдсан "Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам"-ын хүрээнд иргэний мэдээлэл хайх, мэдээлэл хүлээн авах эрхийг хангах зорилгоор 67 төрлийн мэдээллийг ил тод, нээлттэй байлгахаар зохицуулсан. Мэдээлэл хариуцагч байгууллага өөрийн байгууллагын нээлттэй мэдээллийн үнэлгээг тухай бүр шинэчлэх, илгээх нөхцөлийг бүрдүүлэхээр Нээлттэй мэдээллийн систем (www.shilen.gov.mn)-ийн 2.0 хувилбар ашиглалтад нэвтрүүлсэнтэй холбогдуулан 67 нээлттэй мэдээллийг улирал бүр үнэлж "Шилэн Индекс"-ийг тухай бүр нийтэлж байна.

2025 оны I улирлын байдлаар нийт 1,126 байгууллага мэдээллийн ил тод байдлын "Шилэн индекс"-ийн тайланг нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)-ээр дамжуулан илгээсэн ба төрийн захиргааны төв байгууллага 92.61% (Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон 11 яам), төрийн захиргааны байгууллага 79.61% (23 агентлаг), Нийслэлийн Засаг даргын Тамгын газар 55.59% (6 ЗДТГ), нутгийн захиргааны байгууллага 75,84% (14 аймаг)-тай үнэлэгдээд байна. Тус системд II улирлын тайланг 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл хүлээн авч ажиллаж байна гэжээ.

Энэ мэтчилэн 85-100 хувиар үнэлгээ хийгдсэн буюу тодорхой үр дүнд хүрсэн 44 арга хэмжээ байгааг онцлон дурдах нь зүйтэй байна.

Мөн түүнчлэн Монгол Улсын Их хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлүүлт, хүрэх түвшингийн Засаглал хэсгийн 48-д "Цахим засгийн хөгжлийн үзүүлэлт /индекс"-ийг 2030 онд 0,8-д, 2050 он гэхэд 0,9-д тус тус хүргэхээр төлөвлөсөн байх ба биелэлт 100 хувьтай хэрэгжсэн болохыг холбогдох баримтын хамтаар хавсарган хүргүүлсэн.

Гурав. Дүгнэлт

“Алсын хараа – 2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичигт Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан 15 зорилт, 69 арга хэмжээний хэрэгжилтийн тайлагналтад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дараах дүгнэлтэд хүрлээ.

Монгол Улсын Их хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлүүлт, хүрэх түвшингийн Засаглал хэсгийн 48-д “Цахим засгийн хөгжлийн үзүүлэлт /индекс”-ийг 2030 онд 0.8-д, 2050 он гэхэд 0.9-д тус тус хүргэхээр төлөвлөсөн.

НҮБ-н Эдийн засаг, нийгмийн асуудал эрхэлсэн хэлтсээс хоёр жил тутам улс орнуудын “Цахим засгийн хөгжлийн индекс (EGDI)”-ийг судлан гаргадаг.

193 орныг хамруулсан энэхүү судалгаа 3 үндсэн индикаторыг гол үзүүлэлтээ болгодог байна. Үүнд:

1. Онлайн үйлчилгээний индекс – Online Service Index
2. Харилцаа холбоо, дэд бүтцийн индекс – Telecommunication Infrastructure Index
3. Хүний капиталын индекс – Human capital index

Энэхүү гурван бүлэг үзүүлэлт дээр тулгуурлан тоон арга хэрэглэн 193 орны цахим засгийн хөгжлийн индексийг тооцоолон гаргадаг байна.

Судалгааны баг 100 орчим судлаачаас бүрдэх бөгөөд сайн дурын судлаачдыг мөн хамруулдаг байна. Тэдгээрийн тэн хагас нь хөгжиж буй орнуудаас байх ба нийтдээ 65 орчим хэл дээр судалгааг явуулдаг. Монгол Улсын хувьд 2020 онд 193 орноос 92 дугаар байр, 2022 онд 74 дүгээр байранд тус тус орж байсан сайн үзүүлэлттэй.

Иймээс Алсын хараа 2050 урт хугацааны бодлогын баримт бичгийн шалгуур үзүүлэлтийн тайланд НҮБ-с 2024 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр “Цахим засгийн хөгжлийн үзүүлэлт” нийтэлсэн линкийг тайлагнасан байна. Манай улсын хувьд 2024 онд 46 дугаар байранд эрэмбэлэгдсэн буюу цахим засгийн хөгжлийн индекс 0.8-д хүрсэн. Үүнээс гадна E-Participation (2024 EPART: 0.7808) буюу Цахим оролцооны индекс 193 орноос 37-д эрэмбэлэгдсэн бөгөөд ХУР, ДАН систем, “И-Монгол” үйлчилгээний цахимжилтийн үр дүн юм.

Дээрхээс гадна Алсын хараа-2050 урт хугацааны бодлогын баримт бичгийн биелэлтийг тайлагнасан байдалд зарим нэг шүүмжлэлтэй асуудал байгааг дор дурдах нь зүйтэй байна. Тодруулбал:

1. Зорилт, арга хэмжээг зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн эсэхийг оновчтой илэрхийлээгүй;
2. Төлөвлөгөөнд туссан арга хэмжээний хэрэгжээгүй шалтгаан нөхцлийг хангалттай тайлбарлаагүй;
3. Үг, үсэг, тэмдэгтийн болон утга агуулгын алдаатай;
4. Өмнөх буюу 2024 оны тайлагналтаас хойшх ахицыг сайтар дурдагдаагүй;
5. Санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхой илэрхийлээгүй;
6. Арга хэмжээг хэрэгжүүлсэн нотлох баримтаа бүрэн гүйцэд оруулаагүй гэх мэт асуудлууд байлаа. Иймд бодлогын баримт бичгийг тайлагнахтай холбоотой дараах зөвлөмжийг гаргаж байна.

ДӨРӨВ. ЗӨВЛӨМЖ

1. Төлөвлөгөөний биелэлтийг гаргахдаа ҮР ДҮН, НОТЛОХ БАРИМТ-нд тулгуурлах зарчмыг мэргэжилтэн болон нэгжийн удирдлагууд мөрдлөг болгон ажиллах;

2. Төлөвлөгөөний биелэлт нь тухайн байгууллага, нэгж, ажилтан бүрийн хийсэн ажлын үр дүнг харуулдаг тул хугацаа, агуулгыг анхаарах;

3. Хүрэх түвшний тоон үзүүлэлтийг болон чанарыг өдөр тутмын ажилдаа анхаарах;

4. Биелэлтийн хувь бага, эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээг тусгайлан авч үзэж, тодорхой ажлууд төлөвлөн зохион байгуулах;

5. "Алсын хараа - 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийг тайлагнахдаа "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл", "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024, 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр", "Шинэ сэргэлтийн бодлого" зэрэг баримт бичгүүд, тэдгээрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан зорилт арга хэмжээний биелэлттэй уялдуулан тайлагнаж хэвших;

6. Арга хэмжээний биелэлт тус бүр дээр гаргасан санхүүжилтийн мэдээллийг тухай бүр оруулж байх.

Жич: Газар хэлтсийн дарга нар дотоод зохион байгуулалтаар тайлан төлөвлөгөөг гаргаж хэвших. Цагийн менежментийн талаар тодорхой ойлголттой байж, хуульд заасан хугацааг баримталж ажиллах зайлшгүй шаардлагатай болохыг анхаарах.